



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 01 өдөр

Дугаар А/02

Номгон

Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацааг сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын “в”, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2, Засгийн газрын 2020 оны 178, 194 дүгээр тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаас гарсан шийдвэр, Улсын Онцгой комиссын 2020 оны 40 дүгээр хуралдааны тэмдэглэл, аймгийн Засаг даргын 2020 оны А/806 дугаар захирамж, аймгийн Онцгой комиссын 55 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд коронавирус (COVID-19)-ийн халдвараас урьдчилан сэргийлэх, тэмцэх, иргэд, олон нийтийг цар тахлын болзошгүй эрсдэлээс хамгаалах зорилгоор гамшгаас хамгаалах “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг”-т шилжсэн хугацааг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд сунгасугай.

2. Аймгийн Онцгой комисс, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангиуд, шуурхай штабуудын үйл ажиллагаагаа дахин шинэчлэн тодотгож, гамшгаас хамгаалах бэлтгэл, бэлэн байдлыг хангаж ажилласугай.

3. Харьяа нутаг дэвсгэрийн хамрах хүрээнд дотооддоо зарим зохион байгуулалтын арга хэмжээг аймгийн Онцгой комисст уламжилсны үндсэн дээр бие даан шийдвэрлэж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, (Хурандаа Ж.Алтангэрэл)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

1210003